

БМААЭУ-ын ажлын хэсгийн зөвлөмж

Тогтвортой Амжиргаа-II төслийн БМААЭУ-ын бүрэлдэхүүн хэсгийн Ажлын хэсгийн анхдугаар хурал 2009 оны 2-р сарын 4-ний өдрийн 16:50 цагаас 63.5 хувийн ирцтэйгээр хуралдаж, дараах зөвлөмжүүдийг төслийн Удирдах хороонд хэлэлцүүлэхээр хүргүүлж байна.


1. БМААЭУ-ын бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Бэлчээрийн зураглал, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах болон загвар суманд чадавхи бэхжүүлэх” чиглэлээр сонгогдох зөвлөх байгууллагын ажил үүргийн хуваарь, хэмжээнд дараах өөрчлөлтийг оруулах саналтай байна. Үүнд:

а/ Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор зөвлөх байгууллагын хийх ажлыг 2 үе шаттай бус 2009 онд шинээр хэрэгжүүлэх 13 аймагт зэрэг эхлүүлэх,

б/ ХАА-г хөгжүүлэх олон улсын сангийн “Хөдөөгийн ядуурлыг бууруулах” төсөл болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэн хийгдсэн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй Булган, Архангай, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Говьсүмбэр, Орхон аймгийн сумдад бэлчээрийн тоон зураглал, давтан сургалт хийх замаар төслийг зааврын дагуу хэрэгжих нөхцлийг бүрдүүлж бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг санхүүжүүлэх зорилготой БМААЭУ-ын сангийн хөрөнгө оруулалтыг шууд олгох,

в/ Сэлэнгэ, Ховд, Завхан, Сүхбаатар, Говь-Алтай, Дорноговь аймгийн сумдад бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, тоон зураглалыг төслийн удирдамжид заасны дагуу хийж гүйцэтгэх,

2. Бэлчээрийн менежментийн сайн чанарын төлөвлөгөөтэй сумдад төслийн зааврын дагуу (багийн хурал, сумын техникийн хороо, засаг даргын зөвлөлөөр батлагдсан) дэд төслүүдэд БМААЭУ-ын сангаас хөрөнгө оруулалт хийж эхлэх
3. БМААЭУ-ын загвар сумыг сонгох шалгуур үзүүлэлтийг хавсралтаар батлах саналтай байна.

БМААЭУ-ын ажлын хэсгийн ахлагч  П.Баянмөнх

Нарийн бичгийн дарга  С.Батсайхан